



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

198 I . оны II дугаар
сарын 5 . ны өдөр

Дугаар 253

Улаанбаатар
хот

ХҮНСНИЙ ЗАХ НЭЭЖ АЖИЛЛУУЛАХ
ТУХАЙ

Хүнсний бүтээгдэхүүний захын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1981 оны 270 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор ТОГТООХ нь:

1. Улс, хоршооллын байгууллагын туслах аж ахуй, ард иргэдийн амины аж ахуйн илүүдэл бүтээгдэхүүн, байгалийн баялагийг хүлээн авч хөдөлмөрчдөд худалдах болон байгууллага иргэдийг худалдаа хийхэд байр, агуулах, хэмжих хэрэгсэлээр үйлчлэх үүрэгтэй хүнсний захыг аж ахуйн тооцоон дээр II дүгээр сарын 15-ны дотор байгуулж хөдөө аж ахуйн удирдах газрын харьяанд ажиллуулсугай.

АХХГЗ-ийн 1989 оны 161 дүгээр тогтоолоор
2. Хүнсний захын захиргааны контор, худалдааны танхимыг төв цэнгэлдэх хүрээлэнгийн дэргэдэх үзэсгэлэнгийн 4,5 дугаар байранд байрлуулсугай.

3. Хүнсний захын захиргааны эргэлтийн хөрөнгийн нормативыг тогтоож, шаардагдах гүйлгээ хөрөнгийг хотын төсвийн аж ахуйн байгууллагыг санхүүжүүлэх хөрөнгийн хийдэгдлээс олгохыг санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/-т даалгасугай.

4. Хотын хүнсний захад шинээр баригдах барилга байгууламж, засвар тохижилтын зураг төсвийг II дүгээр сард багтаан хийж өгөхийг Хотын архитектур төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/-т үүрэг болгосугай.

5. Хотын төлөвлөгөөний комисс /н.Сумаахүү/-т ДААЛГАХ нь:

а/ хүнсний захад шинээр барих барилга байгууламж, засварын ажлыг БЗН трестийн, орчины зам талбайг цардах тохижуулах ажлыг Зам, барилга ашиглалтын трестийн 1982 оны тө-

лөвлөгөөнд тусгуулан гүйцэтгүүлэх,

б/ шаардагдах тоног төхөөрөмжийн захиалгыг хийж, хөрөнгө оруулалтаар олгох арга хэмжээ авах,

в/ хүнсний захын 1982 оны бэлтгэх ба борлуулах бүтээгдэхүүн, орлого зарлагын төлөвлөгөөг боловсруулж 4-р улиралд хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанд оруулж батлуулах,

г/ туслах аж ахуйтай хотын дэвсгэрийн үйлдвэр, албан байгууллагад 1982 оноос эхлэн хүнсний захад нийлүүлэх буюу борлуулах бүтээгдэхүүний нэр төрлийн төлөвлөгөө өгч байх,

6. Хотын худалдаа удирдах газар /н.Шагдар/, Нийтийн хоолны удирдах газар /н.Баатаржав/ нарт ДААЛГАХ нь:

а/ хүнсний захын захиргаанд шаардагдах хөргөгч лангуу I, пүү 2, жижиг кило 15 ширхэг, ус буцалгагч 2 ширхэг, халад, хормогч, боодлын цаасыг захиалгын дагуу бэлтгэж зохих үнээр олгох;

б/ 1982 оны эхний хагаст багтаан Хүнсний захын дэргэд хүнсний дэлгүүр мухлаг гуанз нээж ажиллуулах.

7. Хүнсний захын худалдааны танхимд ашиглах 2 павильоныг балансаас балансанд шилжүүлж лангуу, тавиур сандлыг түр хугацаагаар гаргаж хэрэглүүлэхийг Төв стадионы захиргаа /н.Даваа/-д даалгасугай.

8. Зураг төсвийн дагуу хүнсний захын барилгын засварыг 1982 оны 4-р сард хийж өгөхийг хотын барилга засварын нэгдсэн трест /н.Доржпүрэв/-т, зам талбай цардах, тохижуулах, талбайн гэрэлтүүлэг хийх ажлыг 1982 оны 5-р сард багтаан гүйцэтгэхийг Зам барилга, ашиглалтын трест /н.Цэдэн-Иш/, Гэрэлтүүлэг чимэглэлийн үйлдвэр /н.Доржготов/-т даалгасугай.

9. Улсын төлөвлөгөөнөөс гадуур бэлтгэсэн ангийн махыг хүнсний захад бэлтгэлийн үнээр нийлүүлэхийг Хотын анчдын бригад /н.Цэнд-Аюуш/-д даалгасугай.

3.

10. Хүнсний захыг хэрэгцээний усаар хангах байнгын ажиллагаатай гүн өрмийн худгийг 1981 онд багтаан барьж ашиглалтанд оруулахыг хотын Усны аж ахуй удирдах газар /н.Адилбиш/-т даалгасугай.

11. Үйлдвэр, албан байгууллага, хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуй, нэгдэл дундын үйлдвэр, хоршоололтой гэрээ байгуулах хүнсний зүйлийн нийлүүлэлт, бэлтгэлийг шуурхай зохион байгуулах ажлын зориулалтад бага даацын машиныг хөлсөөр олгож байхыг хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны Авто бааз /н.Батбаяр/-д даалгасугай.

12. Хүнсний захын гүн өрмийн худгийг ашиглалтанд ортол өдөр тутам зөөврийн усаар хангаж байхын хамт улс хоршооллын байгууллагаас нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг ачиж тээвэрлэхэд шаардагдах ачааны машин үйлчлүүлэхийг Хотын тээврийг удирдах газар /н.Сэрээтөр/-т даалгасугай.

13. Батлагдсан орон тоондоо багтаан эрүүл ахуйн мэргэжлийн шинжээч их эмч I, бага эмч I, лаборант I-ийг хүнсний захад байгуулах шинжилгээний лабораторт байнга ажиллуулахыг хотын АЦХС станц /н.Галсандорж/, Мал эмнэлгийн газар /н.Лувсансамбуу/-т даалгасугай.

14. Хүнсний захыг туслах аж ахуйтай болгох асуудлыг боловсруулж 1982 оны I-р улиралд гүйцэтгэх захиргаанд оруулж шийдвэрлүүлэхийг ХААУ газар /н.Батсүмбэр/-т даалгасугай.

15. Хүнсний захын захиргааны орон тоо, цалингийн фонд-ыг боловсруулж ХНХУХ-нд оруулж II-р сарын 15-ны дотор батлуулахыг Хотын санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/, ХААУ газар /н.Батсүмбэр/-т үүрэг болгосугай.

16. Туслах аж ахуй, амины аж ахуйг хөгжүүлэх талаар нам, засгаас дэвшүүлж байгаа зорилт, хүнсний захын ажиллагааны талаар нийслэлийн хөдөлмөрчид, хотын ойролцоох нэгдэл, Сангийн аж ахуйнуудад хэвлэл, мэдээллийн систе-

мээр өргөн сурталчлахыг ХААУ газар, Зохион зааварлах хэлтэс, Соёлын хэлтэс, Улаанбаатарын мэдээ сонины газарт даалгасугай.


17. Хүнсний захын захиргаанд 2-оос доошгүй телефон утас 1981 онд багтаан тавьж өгөхийг хотын Телефон радио ашиглалтын хороо /н.Баатар/-д даалгасугай.


18. Шинээр ашиглалтанд орж байгаа хүнсний захыг байнгын хяналтандаа авч эргүүлийн маршрут тогтоон, хэв журам зохицуулж ажиллахыг Хотын цагдан сэргийлэх газар /н.Цэдэнсодном/-т даалгасугай.

19. Хүнсний зах ашиглалтанд орсонтой холбогдуулж барааны зах дээр хүнсний бүтээгдэхүүн худалдаалах явдлыг зогсоохыг Захын контор /Мижиддорж/-т үүрэг болгосугай.

20. Хот хоорондын шугамаар ЗХУ-ын Иркутск, Улан-Удэ хотын зах зээлийн ажиллагааны туршлагыг 1982 оны I-р улиралд багтаан судлуулах арга хэмжээ авахыг ХААУ газар /н.Батсүмбэр/, Боловсон хүчин /н.Түмэндэмбэрэл/-д даалгасугай.

21. Энэхүү тогтоолын биелэлтийг гаргаж 1982 оны 5-р сард хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны товчооны хуралд оруулахыг Зохион зааварлах хэлтэс /н.Шарав/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА  С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА  Н.ЖАМБАЛ